



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/255

Хэрлэн сум

Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолын хавсралтын 2.3.6, 2021 оны 24 дүгээр тогтоол, 2023 оны 3 дугаар сарын 09-ний “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөгийн үүр” арга хэмжээний хүрээнд “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн мэргэшүүлэн суралцаж буй албан хаагчдын сургалтын төлбөрт 4,850,000 (дөрвөн сая найман зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Суралцагчдын төлбөрийн мэдээллийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Зөгийн үүр” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 25-ны өдрийн
А/255 дугаар захирамжийн хавсралт

СУРАЛЦАГЧДЫН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН ЗАДАРГАА

№	Суралцагчийн овог, нэр	Ажиллаж буй байгууллага, нэгж	Төлбөрийн хэмжээ	Суралцаж буй сургуулийн нэр	Эзэмшиж буй мэргэжил, мэргэшил
1	Доржийн Оюунсоёмбо	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	1,100,000	Монголын Эдийн засаг бизнес менежментийн академи	Хүний нөөцийн менежер, архив албан хэрэг хөтлөлт, нярав
2	Довчиндугарын Ихэрцэцэг		3,000,000	Дорноговь аймаг Анагаах ухааны коллеж	Сувилагч
3	Батцэнгэлийн Нандинцэцэг		600,000	Этүгэн сургууль	Туслах сувилагч
4	Цэцэгээгийн Эрдэнэбаяр		150,000	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Эмчилгээний хоолны тогооч
Нийт дүн			4,850,000		